



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2018.05.15 № 2-7/2434
танай _____ -ны № _____ -т

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Д.МӨРӨН ТАНАА

Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Журам
батлах тухай” 2009 оны 110 дугаар тушаалд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Хууль зүй, дотоод
хэргийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 14-ний
едрийн А/90 дугаар тушаалыг хүргүүлэв.

Хүлээн авч танилцан, үйл ажиллагаандаа
мөрдөж ажиллана уу.

Хавсралт: 2 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Г.БАЯСГАЛАН





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 14 өдөр

Дугаар A/90

Улаанбаатар хот

┌ Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах ┐ тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Журам батлах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн 110 дугаар тушаалд дараахь нэмэлт оруулсугай:

1. Тушаалын 2 дахь хэсэгт "Гадаадын иргэн, харьяатын газар /Д.Мөрөн/" гэж.

Хоёр. "Журам батлах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн 110 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Гарын хээний нэгдсэн сангийн журам"-д дараахь дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1. Журмын 2.2 дахь хэсгийн дараа "2.3. Гадаадын иргэн, харьяатын газрын оршин суух үнэмлэхний мэдээллийн санд тухайн сард бүртгэгдсэн гадаадын иргэний мэдээллийг зурган хэлбэрт шилжүүлэн, CD, DVD-д хуулбарлаж, битүүмжлэн Гадаадын иргэн, харьяатын газрын эрх бүхий албан тушаалтан өөрийн биеэр сард нэг удаа Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хүргүүлж, тухай бүр бүртгэл хөтөлнө". гэж;

2. Журмын 4.3. дахь хэсгийн дараа "4.4. Гадаадын иргэн, харьяатын газар дараахь үүрэг хүлээнэ. Үүнд:

4.4.1. мэдээлэл бүхий CD, DVD-г хүргүүлэх эрх бүхий албан тушаалтныг томилох;

4.4.2. нэгдсэн санг баяжуулах, хадгалах арга хэмжээ авах;

4.4.3. мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах". гэж.

3. Журмын 1.3.10. дахь заалтын дараа "1.3.11. Монгол Улсад оршин суух үнэмлэх авсан гадаадын иргэн болон албадан гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүн". гэж;

4. Журмын 2.1.4. дэх заалтын дараа "2.1.5. Гадаадын иргэн, харьяатын газрын оршин суух үнэмлэхний мэдээллийн санд бүртгэгдсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүний мэдээлэл". гэж нэмэх;

08 0344

5.Журмын 1.3.9 дэх заалтын "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж" гэснийг "Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр" гэж;

6.Журмын 1.4 дэх хэсгийн "эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа" гэснийг "эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" гэж өөрчлөх;

7.Журмын 1.3.1 дэх заалтын "Захиргааны", 1.3.6 дахь заалтын "Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний үед" гэснийг тус тус хасах.



Д.НЯМДОРЖ